

МОНГОЛ УЛС
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

БАТЛАВ:

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ДЭД САЙД

Д.ЗАГДЖАВ

2020 оны 2-р сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 2020/17

ДАРХАН ХОТ, ТҮҮНИЙ ЗЭРГЭЛДЭЭХ НУТАГ ДЭВСГЭРТ
2020-2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЕОЭКОЛОГИ, ГИДРОГЕОЛОГИЙН
СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

Судалгааны үе шат:	Геозкологи, гидрогеологийн судалгаа	
Судалгааны төрөл:	Сэдэвчилсэн судалгаа	
Судалгааны нэр:	Дархан-Уул аймгийн геозкологи, гидрогеологийн судалгаа	
Судалгааны талбайн байршил:	Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрийн зарим хэсэг	
Талбайн хэмжээ:	2605,7 кв.км	
Координат:	49° 40' 0.0"	105° 45' 0.0"
	49° 40' 0.0"	106° 7' 30.0"
	49° 30' 0.0"	106° 7' 30.0"
	49° 30' 0.0"	106° 22' 30.0"
	49° 25' 0.0"	106° 22' 30.0"
	49° 25' 0.0"	106° 30' 0.0"
	49° 20' 0.0"	106° 30' 0.0"
	49° 20' 0.0"	106° 37' 30.0"
	49° 10' 0.0"	106° 37' 30.0"
	49° 10' 0.0"	106° 22' 30.0"
	49° 12' 30"	106° 22' 30.0"
	49° 12' 30"	106° 7' 30.0"
	49° 10' 0.0"	106° 7' 30.0"
	49° 10' 0.0"	105° 45' 0.0"
Хуудас:	1:25000-ны масштабтай 31 хавтгайн хэмжээнд М-48-92-Б-а,б,в,г, Г-а,б,в,г, М-48-93-А-а,в, В-а,б,в,г, Г-а,в,г, М-48-104-Б-а,б,в,г, М-48-105-А-а,б,в,г, Б-а,б,в,г, М-48-106-А-а,в.	
Код:	ДА геозкологи-2020	

1. Геологийн даалгавар өгөх үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.4 дэх хэсгийн 1 дэх зорилт, Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 16 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.59 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 5.1 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/254 дүгээр тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөө”-ний хүрээнд томоохон хот суурин газруудын геозкологи, гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажлыг хэрэгжүүлнэ.

2. Судалгааны ажлын үндэслэл:

Судлагдсан түвшин: Судалгааны талбайд 1960 онд И.Б.Полицук, В.В.Демидов, С.А.Киселев нарын хийсэн Дарханы районы Орхон гол, Ерөө голын хоорондын бүсийн геологийн тогтоц, ашигт малтмалын судалгаа, 1982 онд Б.Жамсранжав, В.Н.Рябов нарын хийсэн Хүйтэн гол ба Шарын голын орчмын геологийн тогтоц, ашигт малтмалын судалгаа, 1992-1993 онд Б.Батром, Ө.Амар нарын Хойд Хэнтийн металлогений бүс дэх Шарын голын талбайд явуулсан 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил, 1994 онд П.Батчулуун, С.Гомбосүрэн нарын гүйцэтгэсэн Хойд Хэнтийн алтны хүдэржилтийн бүсэд 1:200000-ны масштабын геологийн зураг, 2009 онд Ч.Гончигсумлаа Д.Доржготов нарын Дархан-Уул аймаг, түүний зэргэлдээх нутаг дэвсгэрийн геозкологийн судалгааны ажилд хамрагдсан.

Судалгааны ажлын үндэслэл: Дархан Уул аймгийн нутаг дэвсгэрт нягтралтай суурьшсан хүн ам, өргөн цар хүрээтэй аж ахуйн үйл ажиллагаа болон инженерийн хангамжтай барилга байгууламжийн төвлөрөл, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ, бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, хотжилтийн нөлөөгөөр хүрээлэн буй байгаль орчин ба хүний амьдрах орчинд ихээхэн сөрөг “үүсмэл” өөрчлөлт гарч байна. Иймд геозкологи, гидрогеологийн чиглэлийн судалгаа явуулж, мэргэжлийн үнэлэлт дүгнэлт өгөх шаардлага гарсан.

Эдийн засаг дэд бүтэц: Дархан-Уул аймаг нь засаг захиргааны нэгжийн хувьд 4 сум, 24 багтай, Сэлэнгэ аймгийн сумдтай хил залгаа оршдог. Тус аймаг нь зам, тээвэр, харилцаа холбоо, цахилгаан, дулааны эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбарууд сайн хөгжсөн үйлдвэрлэл, соёл боловсрол, шинжлэх ухааны томоохон төв учраас гадаад орнуудын муж, хот, компани, хувь хүмүүстэй харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлж хамтран ажиллах хамгийн таатай нөхцөл бүрдсэн аймаг юм.

3. Ажлын зорилго:

Дархан хот, түүний зэргэлдээх нутаг дэвсгэрийн хэмжээнд геологи орчин ба байгаль орчны өнөөгийн ерөнхий төлөв байдалд буюу хөрс, агаар, усны бохирдол, түүний тархалт, хотын хог хаягдлын менежмент, үйлдвэрлэл үйлчилгээ, мал аж ахуй, газар тариалангийн хэтийн төлөв, газар хөдлөлийн идэвхтэй хагарал, түүний нөлөөллийн зайнаас үүдэлтэй ус зүйн өөрчлөлт, хөрсний суулт ба гулсалтад суурь

үнэлгээ өгөх, түүнчлэн шаардлагатай тохиолдолд дараагийн шатны судалгаа явуулах объект, хэсгийг ялгаж мэргэжлийн тодорхой зөвлөмжийг гаргана.

Хар төмөрлөгийн үйлдвэр болон бусад уул уурхайн чиглэлээр үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулж байгаа талбай, мөн Мах комбинат, Нэхий Эдлэлийн үйлдвэр зэрэг хүнс, хөнгөн үйлдвэрүүд, түүнээс гарсан хаягдал овоолгийн хэмжээ, түүнд агуулагдах хорт бодис хөрс, усанд нөлөөлөх нөлөө, газар тариалангийн газар ашиглалт, аймгийн усан хангамжийн эх үүсвэр, түүний түвшин, гадаргын болон газрын доорх усны хэмжээ, гидрохимийн найрлагыг судлан геоэкологийн хүчин зүйлүүдтэй хэрхэн уялдаж буй, цаашид үүсэх орчин нөхцөл, сөрөг нөлөөлөлд дүн шинжилгээ хийх, мэргэжлийн зөвлөмж гаргах, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх зорилготой.

4. Судалгааны ажлын зорилтийг шийдвэрлэх үндсэн арга аргачлал, дэс дараалал:

А. Бэлтгэл ажлын үе:

4.1. Төслийн талбайд урьд өмнө гүйцэтгэсэн холбогдох судалгааны материалтай нарийвчлан танилцаж, шаардлагатай баримт, мэдээллийг бүрдүүлэх, ялангуяа гидрогеологи, геоэкологийн региональ судалгааны ажлын төрөл ба арга зүй, аргачлалыг оновчтойгоор сонгох,

4.2. Төслийн талбайн хэмжээнд шаардлага хангасан 1:25000-ны масштабтай байрзүйн зураг бэлтгэх, дагалдахаар дунд масштабын байр зүйн зураг /1:50000, 1:100000/, агаарын фото зураг, сансрын зураг (Астер төрлийн хиймэл дагуулын зураг гэж ойлгоно)-ийн зургийг бүрдүүлж, АСЗ-т тайлал хийх, тухайн талбай хамрагдсан геофизикийн судалгааны (хүндийн хүчний, соронзон зураглал г.м) материалуудтай танилцан боловсруулалт, дүгнэлт хийх,

4.3. Судалгааны ажлын төсөл, төсөв, календарьчилсан төлөвлөгөө зохиох,

4.4. Хээрийн судалгааны ажилд бэлтгэх, шаардлагатай багаж хэрэгслэл, материал, эд зүйлээр хангах, инженер-техникийн багийг бүрдүүлэх.

4.5. Хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох зөвшөөрөл (орон нутаг, тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах гэх мэт), бичиг баримтыг бүрдүүлнэ.

4.6. Хээрийн судалгааны ангид байх зайлшгүй шаардлагатай гэрээ, геологийн даалгавар, ажлын төсөл, төсөв болон холбогдох журам, зааврыг бүрдүүлнэ.

Б. Хээрийн ажлын үе:

4.7. Дархан хот, түүний зэргэлдээх нутаг дэвсгэрийн хэмжээнд геоэкологи-гидрогеологийн нөхцөлийг урьдчилан тандаж, танилцах маршрут ажиглалт явуулах,

4.8. Судалгаанд хамрагдах бүс нутгийн хэмжээнд дөрөвдөгч, геоморфологи, ландшафтын тайлалыг хийх, маршрутын судалгаа явуулах, анхан шатны мэдээллийг боловсруулах,

4.9. Геоэкологи, гидрогеологи, гидрологийн судалгааны чиглэлийн дээжлэлтийн ажлыг гүйцэтгэж, лабораторын шаардлагатай бүх төрлийн шинжилгээ хийлгэх, үр дүнг хүлээн авч боловсруулалт хийх,

4.10. Геоэкологийн хүчин зүйлүүдийг тодорхойлж, зэрэглэл тогтоох, тэдгээрийн бусад судалгааны хүчин зүйлүүдтэй уялдуулах, ус зүйн болон цацрагжилтийн хэмжилтийг гүйцэтгэж, шаардлагатай баримт, мэдээллийг бүрдүүлэх,

4.11. Дээжний тодорхой хувийг байгаль орчны итгэмжлэгдсэн лаборатори болон нийгмийн эрүүл мэндийн газрын лабораторид шинжлүүлэх, гарсан үр дүнд боловсруулалт хийх,

4.12. Шинжилгээ судалгааны үр дүнгийн боловсруулалтад тулгуурлан дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх.

В. Суурин боловсруулалтын үе:

4.13. Завсрын суурин боловсруулалт:

- Завсарын суурин боловсруулалтын ажлыг цаг тухайд нь хийх, судалгааны явцад гарсан асуудлуудын цаг тухайд нь шийдвэрлэх, гадаад дотоод хяналт хийх,
- Төсөл хэрэгжих явцад хийгдэх ба хээрийн судалгаагаар цуглуулсан ажлын материалыг нэгтгэн боловсруулж, баримт бүрдэл, геологи, геоморфологийн тойм зураг, газар хөдлөлийн бүс, геоэкологи, гидрогеологийн болон бусад ажлын зургийг зохиосон байх, хээрийн судалгааны төгсгөлд шийдэж чадаагүй бүх асуудлыг шийдвэрлэх буюу дараагийн үе шатны ажлын үед шийдвэрлэх арга замыг тодорхойлох,
 - Ажлын үр дүнд шаардлага хангасан мэдээлэл өгч чадаагүй тохиолдолд түүнд дүн шинжилгээ хийж, судалгааны арга аргачлалыг өөрчлүүлэх хүртэл саналыг тухайн үед нь тавьж шийдвэрлүүлэх,
 - Бусад үйл ажиллагаандаа холбогдох заавар, аргачлал, геологийн даалгаврын шаардлагыг баримтлана.

4.14. Төслийн эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалт:

- Мөрдөж буй заавар, шаардлагыг бүрэн хангасан анхдагч баримт материалын, геоэкологи, гидрогеологи, зүй тогтол, сорьцлолт, түүний үр дүнгийн зургуудыг 1:25000-ны масштабтаар, геологи, геоморфологийн зургийг 1:50000-1:100000-ны масштабтаар, дээжлэлтийн үр дүнг, төлөв байдал, бусад судалгааны үр дүнг тус тус зохиож, бусад төрөлжсөн зураг, зүсэлт, бүдүүвч, график, хүснэгтийг хавсралт маягаар үйлдэх,
 - Агаар, хөрсний бохирдолт, усан хангамжийн хэтийн төлөв бүхий хэсгүүдэд дагалдах судалгааны ажлын үр дүнгээр зохиогдох ижил утгын зураг болон график, зүсэлтийг 1:5000-1:25000-ны масштабтаар боловсруулах,
 - Судалгааны талбайн хэмжээнд геоэкологи, гидрогеологи, техноген элэгдэл, бохирдолтын түвшинд нөлөөллийн үнэлгээ өгч, зэрэглэл, түвшинг тогтоох, зөвлөмж гаргах,
 - Төслийн зорилго, шаардлагыг хангасан тайланг эцэслэж, тухайн судалгааны ажлаар болон өмнөх судалгааны геологи, геофизик, геохимийн зэрэг холбогдох бусад материалыг нэгтгэн, өөрийн судалгааны ажлын үр дүнтэй уялдуулан дүн шинжилгээ хийсний үндсэн дээр судалгааны талбайн ерөнхий мэдээлэл, ажлын арга, аргачлал, үр дүн болон бүх төрлийн зургийн тайлбар бичиг, геоэкологийн үнэлгээ зэргийг тусгасан тайлангийн бичвэрийг зохиож, хөндлөнгийн шинжээч болон Редакцийн зөвлөлийн дүгнэлтийг гаргуулан, ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулна.

5. Ажлын үр дүн:

Дархан хот, түүний зэргэлдээх нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн ерөнхий төлөв байдалд геоэкологи, гидрогеологийн суурь үнэлгээ өгч, шаардлагатай тохиолдолд цаашид дараагийн шатны геоэкологи, гидрогеологийн нарийвчилсан судалгаа явуулах объект, хэсгийг ялгаж, дараах мэргэжлийн зөвлөмжийг гаргана. Үүнд:

1. Геоэкологи, гидрогеологи, газар хөдлөлийн бүсийн зураг болон бусад дагалдах зураг, схем зохиох,
2. Экологид нөлөөлөгч сөрөг хүчин зүйлүүдийг тодруулах, зэрэглэх, судлах, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх, дүгнэлт хийх.

6. Ажил гүйцэтгэх хугацаа:

6.1. Судалгааны ажлын төсөл, төсөв, календарьчилсан төлөвлөгөө боловсруулж баталгаажуулах:

Эхний жилд: Шууд гэрээгээр

6.2. Хээрийн ажил:

Эхний жилд: Шууд гэрээгээр.

Хоёр дахь жилд: 2020 оны 6-р сараас 10-р сарыг дуустал.

Гурав дахь жилд: 2021 оны 6-р сараас 7-р сарыг дуустал.

6.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт:

2020 оны 11-р сараас 2021 оны 4-р сарыг дуустал.

2021 оны 11-р сараас 2022 оны 4-р сарыг дуустал.

Эцсийн суурин боловсруулалт:

2023 оны 08-р сарыг дуустал.

6.4. Судалгааны ажлын үр дүнгийн тайланд хөндлөнгийн шинжээчээр шүүмж хийлгэх, холбогдох засвар, өөрчлөлтийг хийх, Редакцийн зөвлөлөөр дүгнэлт гаргуулах:

2023 оны 10-р сарыг дуустал.

6.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж, мэргэжилтнээр хянуулж шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр албажуулан ирүүлэх:

2023 оны 11-р сарыг дуустал.

6.6. ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулсны дараа Геологийн баримтын төв архивт тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсаны дараа ажлын 5 хоногт багтаах